



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

23119 Чингис хот, Хэнтий аймаг
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: Khentiiazdtg@yahoo.com

2019.05.16 № 91930
танай _____ -ны № _____ -т

Тодруулга хүргүүлэх тухай

Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зарласан Засаг даргын Тамгын газрын барилга /Хэнтий, Цэнхэрмандал сум/ ЗГХЭГ/201902035 ажлын тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд өөрчлөлт орсон тул дараах тодруулга хүргүүлж байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

1. Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 15%-иас багагүй байх /ТОӨЗ 5.3 (а) заасан/

2. Ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа:


Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 15 хувиас доошгүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж гүйцэтгэсэн байх /ТОӨЗ 5.3 (б)/

Тус ажлын санхүүжилт нь Улсын төсөвт 1 тэрбум 50 сая төгрөгөөр хийгдэхээр батлагдсан ба магадлалаар орж баталгаажсан зураг, төсөв нь батлагдсан төсвөөс илүү гарсан тул ашиг 5 хувь, нэмэгдэл зардал 40 хувиар тооцож тохируулга хийсэн болно. Иймд Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан дүнгээр тооцно.

Захиалагчийг тендерийн урилгад заасны дагуу Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газар гэж хаяглана уу.

Шаардлагатай нэмэлт зургийг файлаар хавсаргасан болно.

ДАРГА



Ж.ГАНБААТАР